



**BASALTWOOL®**  
**МОНГОЛБАЗАЛТ ХК**

МХБ-ийн II ангилалд бүртгэлтэй

**MSE:MBW**

**ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

**2019**

### АГУУЛГА

Гүйцэтгэх удирдлагын захидал	3
Онцлох үзүүлэлт & үйл явдал	4
Эрхэм зорилго, уриа	8
Компанийн танилцуулга	9
Бүтээгдэхүүн	11
Монгол Базальт - Ногоон хөгжилд	12
Бүтэц, зохион байгуулалт	13
Компанийн засаглал	14
Төлөөлөн Удирдах Зөвлөл	15
Гүйцэтгэх удирдлагын баг	19
Хүний нөөц	20
Нийгмийн хариуцлага	22
Хувьцааны мэдээлэл	25
Санхүүгийн үр дүн	26

### Эрхэм хувьцаа эзэмшигчдэд

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхний амар мэндийг эрэн мэндчилье!

Та бүхний өмнө 2019 оны эхний хагас жилээр хийсэн ажлаа тайлагнан дүгнүүлэх хариуцлагатай цаг ирж байна.

Юуны түрүүнд хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч та бүхнийг манай компанийн хувьцаа эзэмшигч болж, инноваци шингэсэн технологи бүхий өрсөлдөх чадвартай үндэсний үйлдвэртээ хөрөнгө оруулан бидний цаашдын амжилтын түүхийг бүтээх хувь нийлүүлэгч болсонд бид гүнээ талархаж байна.

2019 оны эхний хагас жилийн байдлаар бид техник технологи, судалгаа хөгжүүлэлт, бүтээгдэхүүний төрөл стандарт, хэрэглэгчдийн сургалт судалгаа, ажилчдын эрүүл ахуйн орчин, хүний нөөц хөгжүүлэлт, үйл ажиллагааны дотоод болон гадаад менежментийн шинэчилэл, компанийн засаглал, нийгмийн хариуцлага зэрэг тогтвортой хөгжлийн зорилтууд дээр шинэчлэл бүтээн байгуулалтын их ажил хийсэн байна.

Тайлант хугацаанд бид зогсолтгүй хөгжлийн жил гэж харж, үйлчилгээний хэв маягаа шинэчилэн, бүтээгдэхүүний чанар стандартаа сайжруулан, үйл ажиллагааны бүтээмжээ нэмэгдүүлэн, борлуулалтын орлогоо дахин өнгөрсөн оны мөн үеэс 50 орчим хувиар нэмэгдүүлсэн үр дүнтэй ажилласан байна.

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг томоохон үүрэг гүйцэтгэдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компанийн хувьд, бид цаашид Төв Азийн зах зээлд байр сууриа батжуулах, нүүрс хүчлийн хийг бууруулах зорилтуудыг дотоодын болон олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлж буй барилга дэд бүтцийн төслүүдэд идэвхитэй дуу хоолойгоо хүргэн, тогтвортой ханган нийлүүлэгч, идэвхитэй оролцогч байхаар ажиллаж байна.

Мөн түүнчлэн олон нийтийн нээлттэй хувьцаат компани болохын хувьд Компанийн засаглалын тулгуур зарчмын нэг болох “Ил тод байдал”-ын хүрээнд мэдээлэл, тайлагналаа улам бүр сайжруулж, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдад хэрэгтэй агуулга, стандартын дагуу хүргэхээр тасралтгүй ажилласаар байх болно.

### А.ЭНХГЭРЭЛ

Гүйцэтгэх захирал  
“Монгол Базальт” ХК




## ОНЦЛОХ ҮЗҮҮЛЭЛТ & ҮЙЛ ЯВДАЛ

“Монгол Базальт”ХК нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийг хичээн ажилласны үр дүнд тайлант хугацаанд бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаандаа ахиц дэвшил гарган ажиллаа.

### АШИГТ АЖИЛЛАГАА

Тайлант хугацаанд компанид техник, технологийн шинэчлэлийн ажлууд хийгдэж байгаа ч ашигт ажиллагаагаа дээшлүүлж чадлаа.


Компани нийт 123.3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан ба энэ нь нэгж хувьцаанд EPS = 2.19 төгрөг байна.



### БОРЛУУЛАЛТ

Тайлант хугацаанд 1,118.1 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллав.

2018 оны эхний хагас жилтэй харьцуулахад 478.7 сая төгрөг буюу 74.9%-иар өслөө.



### ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛ

“Монгол Базальт”ХК нь олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын хүрээнд техник технологийн шинэчлэл, суурилуулалтын ажлыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж байна.



## ОНЦЛОХ ҮЗҮҮЛЭЛТ & ҮЙЛ ЯВДАЛ

/ Үргэлжлэл /

### ТОП-20 ИНДЕКСИЙН САГСАНД БАГТАВ

“Монгол Базальт”ХК нь Монголын Хөрөнгийн Биржээс тооцдог ТОП-20 индексийн сагсанд багтав. Ингэснээр манай компанийн хувьцаа хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх боллоо.



### ДАРХАН ХОТОД БОРЛУУЛАЛТЫН ТӨВӨӨ НЭЭВ

Монгол Улсын 2 дахь том хот болох Дархан хотод өөрийн борлуулалтын төвөө нээлээ.

Ингэснээр бүтээгдэхүүнээ борлуулах зах зээлээ тэлэхийн сацуу өөрийн хэрэглэгчиддээ хурдан шуурхай хүрэх боломжтой болов.



### НОГООН ЗЭЭЛ

“Монгол Базальт”ХК нь Хас банктай хамтран иргэддээ дулаалгын бүтээгдэхүүнийг худалдан авах боломжийг нээлээ.

Энэхүү зээл нь утааг бууруулахад чиглэгдсэн Базальтвүүл чулуун хөвөн дулаалгын материалаар байшингаа дулаалах зориулалт бүхий ногоон зээл юм.



5 сая.төг хүртэл - 3 жил хүртэлх хугацаатай - 8%-ийн хүүтэй /жилийн/

## ОНЦЛОХ ҮЗҮҮЛЭЛТ & ҮЙЛ ЯВДАЛ

/ Үргэлжлэл /

### ОРОЛЦСОН ҮЗЭСГЭЛЭН, АРГА ХЭМЖЭЭ

**/2019.02.22/**

“PROPERTY INVESTMENT ULAANBAATAR 2019” үзэсгэлэнд “Монгол Базальт”ХК уригдан оролцлоо.

Уг арга хэмжээнд томоохон төсөл хөтөлбөрүүдийн хөрөнгө оруулалтыг үнэ цэнэтэй болгох үүднээс барилгын материал үйлдвэрлэгчдийг оролцуулсан юм.



**/2019.06.20/**

УИХ-н Даргын ивээл дор зохион байгуулагдсан “INNOVATION'S INVESTMENT FORUM-2019” Хөгжлийн Банкны Хөрөнгө Оруулалтын Сангийн зохион байгуулсан форумд оролцож, үйл ажиллагаа, бүтээгдэхүүнээ танилцууллаа.



**/2019.04.22 - 24/**

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Оюуны өмчийн газар, Монголын Брэнд эзэмшигчдийн холбоотой хамтран “Дэлхий Үнэлсэн Монгол Брэнд” үзэсгэлэнд оролцов. Олон Улсад Оюуны өмчид брэнд нэр /BASALTWOOL/ бүртгүүлсэн анхны компаниар тодорсон бөгөөд



## ОНЦЛОХ ҮЗҮҮЛЭЛТ & ҮЙЛ ЯВДАЛ

/ Үргэлжлэл /

### ОРОЛЦСОН ҮЗЭСГЭЛЭН, АРГА ХЭМЖЭЭ

**/2019.04.25/**

Монголын Барилгын Үндэсний Ассоциацийн 10 жилийн ой, “МОНГОЛЫН БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ФОРУМ”-аар “Монгол Базальт”ХК-ийн Гүйцэтгэх захирал А.Энхгэрэл “Тогтвортой Хөгжил ба Ногоон Барилгын Материал” сэдвээр илтгэл тавилаа.



**/2019.03.15-18/**

“УБ Барилга-2019” үзэсгэлэнд оролцож, барилгын материал, барилга барих улирал эхэлж байгаатай холбогдуулан хэрэглэгч нарт барилгын материалаа зөв сонгох талаар зөвлөгөө, мэдээлэл хүргэсэн.



**/2019.05.17/**

“Монгол базальт”ХК нь Дархан-Уул аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимаас зохион байгуулсан жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд компанийнхаа бүтээгдэхүүнээ танилцуулж, сургалтанд хамрууллаа.



## ЭРХЭМ ЗОРИЛГО

Инноваци шингэсэн үйлдвэрлэл технологиороо салбараа манлайлан хөгжүүлж, хүний амьдрах орчинг эрүүл тав тухтай, байгаль дэлхийд ээлтэй, барилга хийцийн эрсдэлгүй, ирээдүй хойчдоо өвлүүлэн үлдээх, ямагт өсөх үнэ цэнэ бүхий баталгаат хөрөнгө оруулалтыг бий болгох



## УРИА ҮГ

1 чулууны 7 гайхамшиг  
Бидний бүтээгдэхүүний цөмд байгалийн чулууны хүч оршино.

## КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

### ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Компанийн оноосон нэр:	“Монгол Базальт” хувьцаат компани
Байгуулагдсан огноо:	2007
Үйл ажиллагааны чиглэл:	Чулуун хөвөнгийн үйлдвэр
Компанийн албан ёсны хаяг:	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Фламинго тауэр, 403 тоот.
	Утас: (976) 7511-4444 Вэб: <a href="http://www.basaltwool.mn">www.basaltwool.mn</a> E-mail: <a href="mailto:monbasalt@rockwool.mn">monbasalt@rockwool.mn</a> Фэйсбүүк: Mongol Basalt JSC

### УДИРДЛАГА, ХҮНИЙ НӨӨЦ

ТУЗ-ийн дарга:	Л.Ариунболд
Гүйцэтгэх захирал:	А.Энхгэрэл
Ажилчдын тоо:	56

### ҮЙЛДВЭРЛЭЛ

Үйлдвэрийн хүчин чадал:	Цагт 1.5 тонн
-------------------------	---------------

### ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Хувьцааны симбол/ код:	MSE:MBW / 544
МХБиржид бүртгэгдсэн:	2018.04.05
Нийт гаргасан хувьцаа:	56,417,000 ширхэг
Хувьцааны ханш:	293 төгрөг /2019.06.30/
Зах зээлийн үнэлгээ:	16.53 тэрбум төгрөг /2019.06.30/

# КОМПАНИЙН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

/ Үргэлжлэл /

“Монгол Базальт”ХК нь 2007 онд Монгол Улсын анхны чулуун хөвөн дулаан тусгаарлагч материалын үйлдвэрээ ашиглалтанд оруулсан.

Бид үйлдвэрээ байгуулахдаа Орос, Герман, Дани, Япон, Хятад зэрэг улсуудын технологи хөгжүүлэлтийн “Эрдэм шинжилгээний байгууллага”-уудтай хамтран ажилласан ба эдгээр улсуудын өндөр технологийн “НОУ ХАУ”-г Монголын базальт чулуунд түшиглэн боловсруулж, өөрийн өвөрмөц орц шийдлийг гарган Монгол Улсын Оюуны Өмчийн Газраар баталгаажуулан патент авсан юм.

Ийнхүү манай компани өнгөрсөн 12 жилийн хугацаанд “BASALTWOOL” брэнд нэрээр дотоодын барилга, аж үйлдвэрийн салбарын хэрэглэгчид болон иргэддээ бүтээгдэхүүнээ нийлүүлж байна.

“Монгол Базальт”ХК нь цаашид үйл ажиллагаандаа шинэлэг арга техник, стандарт, шинэ санааг тогтмол туршин хөгжүүлсний үр дүнд олон улсын зах зээлд бүтээгдэхүүнээ нийлүүлэх зорилго тавин ажиллаж байна.

## ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ЗОРИЛТ

### 2022

#### ● Брэндиг хөгжүүлэлт

- BASALTWOOL® брэндийг зорилтот зах зээлд, хэрэглээний өргөн сонголттой, техникийн давуу шийдэлтэй, үнээр өрсөлдөх чадвартайгаар дотоодын болон гадаадын зах зээлд амжилттай нэвтрүүлэх
- Төв Азийн Базальт Дулаалгын Материалын #1 үйлдвэрлэгч, борлуулагч болох

#### ● Борлуулалт

- 2022 он хүртэл жил бүр дунджаар 45%-ийн өсөлт гарган компанийн нийт борлуулалтыг 14 тэрбум төгрөг болгох
- Гадаад зах зээл дээр BASALTWOOL® брэндийн дистрибьюторын үйл ажиллагааг тэлэх
- 2021 он гэхэд борлуулалтын 50%-60%-ийг гадаадын экспорт бүрдүүлдэг болох
- Дотоод зах зээл дээр тэргүүлэгч байр суурийг тогтоон, дэлхийн жишигт нийцсэн чанар стандарттай бүтээгдэхүүн үйлчилгээг дотоодын хэрэглэгчдэд нийлүүлэх

#### ● Чанар

- Бүтээгдэхүүний чанарын удирдлагын тогтолцоог сайжруулах, олон улсын ISO 9001:2015 стандартыг 2020 он гэхэд нэвтрүүлэх

#### ● Бүтээгдэхүүн хөгжүүлэлт

- BASALTWOOL® брэндийн 5 бүтээгдэхүүнтэй болох

Чулуун хөвөн хавтан / batts /

Чулуун хөвөн уян / flexible /

Чулуун хөвөн шүршдэг / spray wool /

Чулуун хөвөн шугам хоолой / pipe /

Чулуун хөвөн шавардлагатай / cement mortar BASALTWOOL® /

# БҮТЭЭГДЭХҮҮН

## BASALTWOOL - ЧУЛУУН ХӨВӨН ХАВТАН



## BASALTWOOL - ШУГАМ, ХООЛОЙН ДУЛААЛГА




## ШҮРШДЭГ - BASALTWOOL



## BASALTWOOL - ХЭСЭГЧЛЭН УГСРАХ СЭНДВИЧ



## BASALTWOOL - ФАЙБЕР ХАВТАН



### Галд шатдаггүй

-180°C +1,100°C-т тэсвэрлэх тул галын эрсдлээс бүрэн хамгаална



### Халуун болон хүйтнээс тусгаарлана

Дулаан дамжуулах коэффициент  $k=0.036\text{Вт/мк}$



### Ус, чийг шингээхгүй

Усны уурын тархалтыг тэсвэрлэх коэффициент  $k=1$  буюу агаарынхтай тэнцүү



### Гажилтанд тогтвортой

90%-ийн харьцангуй чийгшил ба +700°C дахь өөрчлөлт 1%-аас хэтрэхгүй



### Дуу чимээг шингээж тусгаарлана

45ДБ-аас дээш тусгаарлана

“Монгол Базальт”ХК-ийн гол бүтээгдэхүүн болох Базальт чулуун хөвөн нь дулааны алдагдлыг бууруулаад зогсохгүй үйлдвэрлэлийн явцад гарсан хаягдалыг дахин боловсруулах боломжтойгоороо давуу талтай.

Иймд бид бизнесийн үйл ажиллагаа, нийгмийн хариуцлагын хүрээнд “Нэгдсэн Үндэсний Байгууллага”-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудыг мөрдлөг болгон ажиллахаар зорьж байна.

Энэ хүрээнд Тогтвортой хөгжлийн зорилтуудын 3, 9, 11, 12, 13 дугаар зорилтуудыг хангаж ажиллахаар зорих ба дэлхий дахины ирээдүйн тогтвортой хөгжилд өөрсдийн хувь нэмрээ оруулах болно.




Өнөөдөр 2030 он хүртэл тунхагласан уг 17 Тогтвортой Хөгжлийн Зорилтыг дэлхийн ТОП аж ахуйн нэгжүүд өөрсдийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж эхлээд байна.

“Монгол Базальт” хувьцаат компани энэхүү зорилтыг хэрэгжүүлэх нь манай эрхэм зорилго, нийгмийн хариуцлагын нэг чухал хэсэг болохоос гадна бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлд гаргаж үйл ажиллагаагаа өргөжинад дэмжлэг болох юм.



## БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

“Монгол Базальт”ХК-ийн хувьд компанийн засаглал гэдэг нь хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг үнэ цэнэтэй, үр өгөөжтэй болгохын тулд нийт Хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлага болон бусад оролцогч талууд хоорондын итгэлцэл, бүхий л харилцаа, үүрэг, хариуцлагын зохистой харьцааг тогтооход чухал ач холбогдолтой үйл явц, тогтолцоо юм.

Компани нь компанийн засаглалын чухал хэмжүүр болох ил тод байдлаа улам сайжруулан төгөлдөржүүлэхээр зорин ажиллаж байна.

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

“Монгол Базальт”ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал /ХЭХ/ бөгөөд ХЭХ нь ээлжит болон ээлжит бус гэсэн хоёр хэлбэртэй байна. ХЭХ-ийг Төлөөлөн удирдах зөвлөл болон “Компанийн тухай хууль” болон компанийн дүрэмд заасан үндэслэлээр зарлан хуралдуулж болно.

### 2019 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

“Монгол Базальт”ХК нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 2019.04.29-ний өдөр хуулийн хүчин төгөлдөр 71.11%-ийн ирцтэй хуралдлаа.

Энэ удаагийн хурлаар хэлэлцсэн 1.Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах асуудлыг хуралд оролцосон хувьцаа эзэмшигчид 100%, 2. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох асуудлыг 99.98%, 3. Компани хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг зөвшөөрөх эсэх асуудлыг 99.72%, 4. Хайлах зуухны шинэчлэлийн хүрээнд үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, технологийн шинэчлэл хэрэгжүүлэх төслийг батлах асуудлыг 99.52%-иар тус тус зөвшөөрсөн юм.

### 5%-ААС ДЭЭШ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Хувьцаа эзэмшиг	Хувь хэмжээ
Л.Ариунболд	35.7%
А.Энхмаа	7%
А.Энхгэрэл	7%
А.Энхжин	7%
П.Сайнбилэг	13.3%

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ нь “Компанийн тухай хууль” болон “Монгол Базальт” ХК-ийн дүрэмд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага юм.

ТУЗ нь компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд хяналт тавих, чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадна хувьцаа эзэмшигчдийн эрхийг компанид төлөөлөн хамгаалдаг.

ТУЗ нь жил бүр компанийн стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний биелэлтийг тогтмол хянан, холбогдох үүрэг, чиглэлийг гүйцэтгэх удирдлагад өгч ажилладаг.

“Монгол Базальт” ХК-ийн одоогийн ТУЗ нь 2019 оны 04 сарын 29-ны өдөр болсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас сонгогдон ажиллаж байна.

ТУЗ-ийн Нарийн бичгийн даргаар **Б.Амарбаясгалан** ажиллаж байгаа бөгөөд тэрээр 2007-2008 онд “Нако Түлш”ХК-ийн ТУЗ-н гишүүн, 2005-2017 онд “Хөх ган”ХК-ийн ТУЗ-н Нарийн бичгийн даргаар, 2013-2017 онд “Би Ди СЕК”ҮЦК-ийн Хөрөнгө оруулалтын албаны ахлах менежер, 2018 оноос “Монгол Базальт”ХК-ийн ТУЗ-н Нарийн бичгийн даргаар ажиллаж байна.

### ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

ТУЗ нь дэргэдээ дараах 3 дэд хороотой үйл ажиллагаагаа явуулж ба “Монгол Базальт” ХК-ийн 2019 оны 6 сарын 5-ны өдрийн ТУЗ-ийн хурлаас Аудитын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороо нь дараах бүрэлдэхүүнтэй томилогдон ажиллаж байна.

#### 1. Аудитын хороо

Дарга: Ч. Зоригтбаатар, гишүүд: Б.Шаравсамбуу, Т.Цэнд-Аюуш

#### 2. Нэр дэвшүүлэх хороо

Дарга: Ш.Энхтөр, гишүүд: Хан Гю Бунг, Т.Цэнд-Аюуш

#### 3. Цалин урамшууллын хороо

Дарга: Л.Ариунболд, гишүүд: Ч.Зоригтбаатар, Ш.Энхтөр



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ - ХАРААТ БУС ГИШҮҮД

### ШАРАВСАМБУУ ЭНХТӨР

Мэргэжил: Эрх зүйч, Банкны Удирдлага

#### Боловсрол:

1987-1992 он: Хилийн Цэргийн Командын Дээд Сургууль-Командын Офицер

1993-1997 он: МУИС, Хууль Зүйн Их Сургууль- Эрх Зүйч

2000-2004он: СЭЗИС- Банкны Удирдлага

#### Ажил эрхлэлт ба ажлын туршлага:

1997-2009 он: Худалдаа Хөгжлийн Банк,- Хуульч, Ахлах хуульч , Газар Хэлтсийн дарга

2009-2013он: Хадгаламж Банк- Газрын Захирал

2013-одоог хүртэл Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Монголын Хуульчдын холбоо- Өмгөөлөгч

### ЧАНСАА ЗОРИГТБААТАР

Мэргэжил: Хуульч, Эдийн засагч

#### Боловсрол:

Санхүү Эдийн Засгийн Дээд Сургууль- Банк, Санхүүгийн Эдийн Засгийн Баклавр

МУИС, Хууль Зүйн Их Сургууль- Хууль Зүйн Магистр, Эрх Зүйч

#### Ажил эрхлэлт ба ажлын туршлага:

1996-1997 он: Төрийн Өмчийн Хороо- Хуулийн Зөвлөх

1997-1998 он: Хууль Зүйн дунд Сургууль – Хичээлийн эрхлэгч

1998-2007 он: Монгол Банк – Хуулийн хэлтэсийн мэргэжилтэн

2007-2008 он:Зоос банк – Эрх зүйн газрын захирал

2008 оноос Лекс Коунсел ХХК- Гүйцэтгэх захирал

### ТҮВШИНТӨРИЙН ЦЭНД-АЮУШ

Мэргэжил: Бизнесийн удирдлага, Компанийн засаглалын эксперт, Эдийн засагч

#### Боловсрол:

2000-2012 он: МУИС- Бизнесийн Удирдлага

1998-1999 он: МУИС- Эдийн засгийн ухааны магистер

1988-1992 он: МУИС- ЭЗФ, Үйлдвэрлэлийн удирдлага ба эдийн засгийн баклавр

#### Ажил эрхлэлт ба ажлын туршлага:

1993-2005 он: СЭЗДС-ийн Багш

2006-2008 он: Зөвлөгөө өгөх төвийг хариуцсан СЭЗДС-ийн дэд захирал

2007-2009 он: Амжилтын хөтөч ТББ-ийн Гүйцэтгэх захирал

2009-2013 он: КЗХТ-ийн ТУЗ-ийн Нарийн Бичгийн Дарга

2013 оноос одоог хүртэл СЭЗИС-ийн профессор

2016 оноос одоог хүртэл СЭЗИС-ийн КЗХТ-ийн хамтарсан

Компанийн засаглалын МВА-ийн хөтөлбөрийн эрхлэгч,

2014 оноос одоог хүртэл СЭЗИС-ийн ТУЗ-ийн нарийн Бичгийн дарга

2013 оноос одоог хүртэл КЗХТ-ийн Гүйцэтгэх захирал

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ - ЕРДИЙН ГИШҮҮД

### ЛХАГВАЖАВ АРИУНБОЛД

Мэргэжил: Цахиурын исэлд суурилагдсан эрдэсийн хайлах болон дулаанаар боловсруулах технологийн үйлдвэрийн инженер, Эдийн Засагч

#### Боловсрол:

ЗХУ-ын Свердловскийн Уралын Политехникийн дээд сургуулийн “Силикатын технологи”-ийн факультет, АНУ-ын Колорада Эдийн засгийн их сургууль

#### Ажил эрхлэлт ба ажлын туршлага:

1987-1990 он: БЦУГ-ын Засвар механикийн заводад Ерөнхий механик, Ерөнхий инженер,

1990-1993 он: Автомашин салхины шилний Төслийн удирдагч, Төслийн үр дүнд Автомашин салхины шилний үйлдвэр “Чин” ХХК байгуулагдсан.

1999-2012 он: “Моншил” төслийн удирдагч, Төслийн үр дүнд Шилэн лонхны үйлдвэрийн төсөл

2005 оноос чулуун хөвөн дулаан тусгаарлагч материалын үйлдвэрийн төслийг санаачлагч, төслийн удирдагч,

2007 оноос “Монгол Базальт” компанийн үүсгэн байгуулагч, Ерөнхий захирал

2018 оны 9 сараас “Монгол Базальт” ХК-ийн ТУЗ-ийн дарга

### ГАЛБАДРАХ ГАНЗОРИГ

Мэргэжил: Цэргийн командлагч, Улс төр судлаач

#### Боловсрол:

1976-1980 он: Одессит ЦНДС

1990-1992 он:Улс төрийн их сургууль

2006-2008 он: БХИС-Удирдлагын академи

#### Ажил эрхлэлт ба ажлын туршлага:

1997-2008 он: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт-Тоо бүртгэл, нөхөн хангалтын офицер

2008-2011 он: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт- Батлан хамгаалах хууль тогтоомж, хяналт шинжилгээ

хариуцсан ахлах офицер

2011-2013 он: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт-Цэргийн штабын орлогч дарга

2016-оноос “Монгол Базальт” ХК Шугам хоолой дэд бүтэцийн дулаалгын төслийн багийн удирдагч

### ПҮРЭВБАНЗРАГЧ САЙНБИЛЭГ

Мэргэжил: Технологийн Инженер, Санхүүч

#### Боловсрол:

ПТДээд сургууль- Технологийн Инженер

СЭДС- Банк зээлийн эдийн засагч –Санхүүч

#### Ажил эрхлэлт ба ажлын туршлага:

1995-2000 он: Сайн Сан ХХК- Захирал

2000-2007 он: Жи Ви Эн ХХК- Гүйцэтгэх Захирал

2007 оноос “Монгол Базальт” ХК Санхүү эрхэлсэн захирал

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ - ЕРДИЙН ГИШҮҮД

/ Үргэлжлэл /

### АРИУНБОЛД ЭНХГЭРЭЛ

Мэргэжил: Үйлдвэр Үйл ажиллагааны Менежмент, Санхүү Менежмент

#### Боловсрол:

2014 - 2017 Санхүү Эдийн Засгийн Их Сургууль

2008 - 2011 Лондон Метрополитан Их Сургууль

#### Ажил эрхлэлт ба ажлын туршлага:

2008 - 2011 он: Лондон, "ЛУКСОТИКА" компанийн Кингстон салбарын Менежер

2011 - 2012 он: "Мянганы Сорилтын Сан" – Crown Agents-Худалдан Авах Газрын Менежер

2013 - 2017 он: "Монгол Базальт" ХК Олон улсын төсөл хариуцсан Захирал

2017 - 2018 он: "Монгол Базальт" ХК –н ТУЗ-н гишүүн, Үнэт Цаас Хариуцсан мэргэжилтэн

2018 оноос "Монгол Базальт" ХК-н Гүйцэтгэх Захирал

### БАДРАХ ШАРАВСАМБУУ

Мэргэжил: Нягтлан бодогч, Гавьяат Эдийн засагч, / PhD Доктор цол, Эдийн Засгийн Ухааны Доктор /

#### Боловсрол:

1965 он: Улаанбаатар худалдааны Техникум

1975 он: Улс Ардын Аж Ахуйн Дээд Сургууль

#### Ажил эрхлэлт ба ажлын туршлага:

1979-1984 он: Худалдаа Бэлтгэлийн Яам- Орлогч Сайд

1984-1990 он: Худалдаа Бэлтгэлийн Яам- Сайд

1990-он: Сайд нарын Зөвлөлийн - Орлогч Дарга

1991-1994 он: Москва-д Суугаа ЭСЯ-1-р Нарийн Бичгийн Дарга

1994-1996 он: Гаалийн Ерөнхий Газар- Дарга

1996-1998 он: Улаанбаатар Импекс Компани- ТӨ ҮҮГ- Ерөнхий захирал

1996-2000 он: Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд Сургууль-

Маркетингийн Тэнхимийн Эрхлэгч

2000-2004 он: Улсын Их Хурлын Гишүүн

2005-2011 он: Санхүүгийн Зохицуулах Хороо- Орон тооны Гишүүн, Дэд дарга

### HAN KYU BONG /ХАН ГЮ БУНГ/

Мэргэжил: Бизнес удирдлагын мастер

#### Боловсрол:

1981-1985 он: БНСУ-н Их Сургууль –Бизнес Удирдлагын Баклавар

2007 он: БНСУ-н Их Сургууль – Бизнес удирдлагын Мастер

#### Ажил эрхлэлт ба ажлын туршлага:

1999-2006 он: Hyundai, салбарын дарга,

2006- 2013 он: Гаули Инвестмент, Гүйцэтгэх захирал,

2013 оноос хойш Гаули ҮЦК, Гүйцэтгэх захирлаар ажиллаж

байна. Тэрбээр үнэт цаасны зах зээл дээр нийт 32 жил ажилласан

туршлагатай бөгөөд БНӨСҮ-ын ҮЦЗЗ дээр 2,3 их наяд вонын

хөрөнгийг татан төвлөрүүлсэн, МУ-ын ҮЦЗЗ дээр 127 тэрбум

төгрөгийг санхүүжилтийг татан төвлөрүүлсэн байна.

## ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ



### А.ЭНХГЭРЭЛ

/ Гүйцэтгэх захирал /

#### Д.САЙНБААТАР

Ерөнхий Менежер  
Инженер Эдийн Засагч, Бизнес удирдлага  
2010-оноос "Монгол Базальт" ХК-ийн Ерөнхий менежер

#### П.БААСАН-ОЧИР

Ерөнхий инженер  
Технологийн Инженер мэргэжилтэй.  
2014-2016: "Бэрэн Групп" ХХК Технологийн Инженер  
2016-2017: "Тэнгэрийн Хишиг" ХХК Ерөнхий Инженер  
2017- оноос "Монгол Базальт" ХК-ийн Ерөнхий Инженер

#### Б.НАРАНГЭРЭЛ

Ерөнхий нягтлан бодогч  
Худалдааны Нягтлан Бодогч -Эдийн засагч / Мэргэшсэн Аудитор  
1983-1991: Завхан ХБУГазар Байцаагч – Орлогч Нябо  
1991-2018: Мэргэшсэн Нягтлан бодогч/ Зөвлөх Аудитор  
2019 оноос "Монгол Базальт" ХК-ийн Ерөнхий Нягтлан Бодогч

#### Ц.БАЙГАЛМАА

Дотоод хяналтын аудитор  
Нягтлан Бодогч/Дотоод хяналтын мэргэшсэн аудитор  
1987-1992: ХБТрест Төрийн Байгууллагад Эдийн Засагч  
1992-2012: "Халиун" ХХК Нягтлан Бодогч  
2014-2016: "Дулааны Шарын Гол" ХК Дотоод хяналтын аудитор  
2019 оноос "Монгол Базальт" ХК-ийн Дотоод хяналтын аудитор

## ХҮНИЙ НӨӨЦ



“Монгол Базальт” ХК нь “ЭРХЭМ ЗОРИЛГО”-доо хүрч, хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгийг тасралтгүй нэмэгдүүлж, компанийнхаа үнэ цэнийг өсгөн ажиллахад манай хамт олон, нийт ажиллагсдын хүч хөдөлмөр, авьяас чадвар нэн чухал юм.

Иймд манай компани хүний нөөцийн уян хатан, үр өгөөжтэй бодлогыг хэрэгжүүлэн ажилладаг ба ажилтнуудаа чадавхжуулан хөгжүүлэх, зах зээлд өрсөлдөхүйц цалин урамшуулал олгох, нийгмийн асуудлаа шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэн урт хугацаанд тогтвортой, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэхээр зорин ажиллаж байна.

## ХҮНИЙ НӨӨЦ

/ Үргэлжлэл /



2019 оны эхний хагас жилд шинээр эдийн засагч, тооцооны нягтлан бодогч, дотоод аудитор, үйлдвэрийн инженер технологич, борлуулалт маркетингийн мэргэжилтэн, сургалт зөвлөлгөө хариуцсан инженер, үндсэн хөрөнгө бараа материалын нярав, ээлжийн тогооч, гал тогооны туслах ажилтан, автын механик инженер, засварын механик, цахилгааны техник, центрфугийн засварчин, ачаалагчийн оперотор зэрэг ажлын байрыг шинээр бий болгож, нийт 14 хүнийг ажлын байраар хангасан.

Компанийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, чадавхийг дээшлүүлэх, хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэлтийн ажлын хүрээнд “BIZNETWORK” ажлын байрны зарын нэгдсэн сайт болон нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сантай байнгын хамтран ажиллаж, хэрэгцээт ажлын байрны захиалга, идэвхижүүлэлтийг тасралтгүй явуулснаар 2019 оны хаврын төгсөгчдөөс мэргэжлийн ажилтан 1, инженер техникийн ажилтан 2, санхүү бүртгэлийн ажилтан 1, нийт 4 ажилтан шинээр ажилд авч дадлагажуулан ажиллуулж байна.

## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

“Монгол Базальт” ХК нь үндэсний үйлдвэрлэгч, олон нийтэд нээлттэй хувьцаат компани болохын хувьд Монгол Улсын хөгжил дэвшил, нийгмийн сайн сайхан, залуу хойч үеийнхээ ирээдүйн төлөө өөрийн хувь нэмэр оруулахыг зорин ажилладаг.

Энэ хүрээнд тайлант хугацаанд олон нийт, хүүхэд залуучуудад чиглэсэн хэд хэдэн төслүүдийг амжилттай хэрэгжүүлснээ тоймлон тайлагнаж байна.

### ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДАД ЧИГЛЭСЭН

Байгальд ээлтэй эко технологээр үйлдвэрлэгдсэн “BASALTWOOL” нэрийн бүтээгдхүүний хэрэглээ, ач холбогдлыг сурталчлах зорилгоор компанийн ажилтнуудын болон нийт хүүхдүүдийн дунд гар зургийн уралдааныг зохион байгуулж, оролцогчдыг шагнаан урамшуулж, хүүхдийн баярын арга хэмжээг “Мишээл экспо” төвд байрших компанийн SHOW ROOM-д амжилттай зохион байгууллаа.



Оюутнуудын дадлагын хугацаанд олж авах мэдлэг, чадварыг дээшлүүлэх, үндэсний үйлдвэрээ дэмжих сэтгэлгээг хөгжүүлэх, бүтээлчээр ажиллах урам зоригийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол - Германы хамтарсан техникийн коллежийн дадлагажигч оюутнуудыг ажлын байраар хангаж, дадлагын хугацаанд 1,000,000 /нэг сая/-ийн тэтгэмж олгон дэмжиж ажиллалаа.

## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

/ Үргэлжлэл /

### ИРГЭД, ОЛОН НИЙТЭД ЧИГЛЭСЭН

Монголын эмэгтэйчүүдийн сангийн захиалгаар өрх толгойлсон эмэгтэйчүүдийг дэмжих, тэдний амьжиргааны түвшинг дээшлүүлэх, эрүүл ахуйн баталгаат эко жишиг орчин бий болгох зорилгоор компанийн өөрийн үйлдвэрлэсэн бүтээгдхүүнийг ашиглан 40м2 орон сууцыг 1 сарын дотор барьж байгуулан ашиглалтанд оруулаад байна.

Барилгын хөгжлийн төвөөс өндөр настны тэтгэвэрт гарсан ахмад Өөдөсийн байшингийн хана дээврийг дахин дулаалж, гадна өнгөлгөө, дээврийг шинэчлэн цахилгаан халаагуур тавьж, хаалга болон гал тогооны тавилгыг шинэчлэх ажлын гүйцэтгэлд 7.0 сая төгрөгийг зарцуулж, компанийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна.

Чингэлтэй дүүргийн 8,9,10-р хорооны иргэдийн дахин дулаалгын аянд хамрагдсан 54 айлын “Шинэ хороо” төслийн ажлыг амжилттай дуусган хүлээлгэн өглөө.

Агаарын бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлтийг нэмэгдүүлэх, нүүрс хүчлийн хийг бууруулах, УБ хотын нийгмийн эрүүл мэнд ахуйн хөгжлийг сайжруулах, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангах чиглэлээр хийгдэж буй “Цэвэр агаар” сангийн дахин дулаалгын төсөлд амжилттай оролцож, 11 айлын дахин дулаалгыг өөрийн үйлдвэрлэсэн чулуун хөвөн, уур ус тусгаарлагч бүтээгдхүүнийг ашиглан гүйцэтгэсэн.



Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 5 дугаар сургууль, 22-р цэцэрлэг, 19-р хорооны өрхийн эмнэлэгийн дулааны алдагдлыг хэмжиж, дүгнэлт гарган зөвлөлгөө өгч ажилласан.

# НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

/ Үргэлжлэл /

## АЖИЛЧДАД ЧИГЛЭСЭН

Компанийн ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран ажиллах гэрээг байгуулж, 2019 оны 6-р сард ажилтнуудыг цогц үзлэгт бүрэн хамруулснаар гэрээний гүйцэтгэлд 1,360.0 мянган төгрөг зарцууллаа.



Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, ажлын байранд илчлэг, халуун хоол ундаар хангах зорилгоор ажилчдын цайны газрыг өргөтгөн, сайжруулах ажлыг худалдаа, нийтийн хоолны тоног төхөөрөмж үйлдвэрлэл, худалдааны “Тулга техник” компанитай хамтран зохион байгуулж, 27,0 сая төгрөгийн үнэ бүхий орчин үеийн шаардлага хэрэгцээг хангасан тоног төхөөрөмж, тавилга эд хогшлийг байршуулан үйл ажиллагааг жигдрүүлэн ажиллаж байна.

Үйлдвэрийн үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, ажлын байрны эрүүл ахуйг хангах, ажилтнуудын хөдөлмөрийн эрүүл ахуй, орчны нөхцөлийг сайжруулах зорилгоор хөдөлмөрийн нөхцөл тодорхойлох тусгай зөвшөөрөл бүхий “Хэлт энд Сэфти Солушинс” компанитай хамтран ажиллаж, барилгын дулаан тусгаарлагч чулуун хөвөнгийн үйлдвэрийн ажилтнуудын ажлын байрны нөхцөлийн үнэлгээг хийлгэн, цаашид хамтран хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

# ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Симбол: MSE:MBW | Код: 544

**Хувьцааны ханш** >>> Хаалтын ханш: (2019.06.30) **▲ 293.0₮ 51.9₮ (21.5%)** Өмнөх ханш: (2018.12.31) **241.08₮**

2019 оны эхний хагас жилд “Монгол Базальт”ХК-ийн хувьцаа зах зээл дээр идэвхитэй байсан нь хувьцааны ханшийг өсгөх гол нөхцөл болов.

Энэхүү өсөлт нь тайлант хугацаанд МХБирж дээр өндөр өсөлт үзүүлсэн хувьцааны нэгд багтаалаа.

Хувьцааны дээд ханш нь 298₮, доод ханш 231₮, дундаж ханш 261₮ байсан юм.



## Хувьцааны арилжаа

Тайлант хугацаанд үнэт цаасны хоёрдогч зах зээл **1.89** сая ширхэг хувьцаа **499.43** сая төгрөгөөр арилжигдлаа.

Хөрөнгө оруулагчдын бүтцийг харвал **96%** нь гадны хөрөнгө оруулагчид байгаа бол **4%** нь дотоодын тоглогчид байв.

Ийнхүү гадны урт хугацааны хөрөнгө оруулагчид манай хувьцааг сонирхон хөрөнгө оруулж байгаа нь цаашид урт хугацаанд тогтвортой өсөлт үзүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Үнэт цаасны арилжаанд эзлэх хувь хэмжээ

	Арилжигдсан ширхэг /мян.ш/	Үнийн дүн /сая.төг/	33-ийн нийт арилжаанд эзлэх хувь	II ангилалын арилжаанд эзлэх хувь
2019.01.31	262.61	70.80	2.16%	6.10%
2019.02.28	123.20	31.32	1.43%	6.67%
2019.03.29	247.45	61.51	1.58%	3.61%
2019.04.30	274.40	66.69	3.33%	8.82%
2019.05.31	350.78	88.90	4.44%	11.31%
2019.06.30	636.19	180.20	6.60%	19.46%


**Зах зээлийн үнэлгээ** >>> **▲ 16.53** тэр.төг (2019.06.30) **2.93** /тэр.төг/ (21.5%) Өмнөх үнэлгээ: (2018.12.31) **13.60₮** /тэр.төг/

Эхний хагас жилийн байдлаар “Монгол Базальт”ХК-ийн үнэлгээ нь нийт зах зээлийн үнэлгээний 0.6%-ийг эзэлж байна.

## Хувьцаа эзэмшигчид

“Монгол Базальт” ХК нь 2019.06.30-ны өдрийн байдлаар **2,300** хувьцаа эзэмшигчтэй байгаа ба 5%-аас дээш хувь эзэмшдэг 5 хувьцаа эзэмшигч, 5%-аас бага хувьцаа эзэмшдэг 2,295 хувьцаа эзэмшигч байна.

Нийт хувьцаа эзэмшигчдийн 2.3% нь гадны хөрөнгө оруулагчид байгаа нь бусад компаниудтай харьцуулахад өндөр үзүүлэлт юм.



## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

( '000 төгрөгөөр )

ҮЗҮҮЛЭЛТ	2018.06.30	2019.06.30
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгөн хөрөнгө	4,951,699.1	1,163,649.6
Дансны авлага	951,044.7	309,248.3
Татвар, НДШ-ийн авлага	7,996.1	50.5
Бусад авлага	-	40,660.7
Бараа материал	979,091.5	1,338,170.8
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4,862.4	2,959,778.1
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>6,894,693.8</b>	<b>5,811,558.0</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	-	-
Үндсэн хөрөнгө	19,246,210.4	22,556,223.4
Биет бус хөрөнгө	2,801,530.7	11,190.8
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>22,047,741.1</b>	<b>22,567,414.2</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>28,942,434.9</b>	<b>28,378,972.2</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>	-	-
<b>Өр төлбөр</b>	-	-
Богино хугацаат өр төлбөр	-	-
Дансны өглөг	504,392.2	55,475.9
Цалингийн өглөг	-	30,468.3
Татварын өр	9,928.1	161,792.5
НДШ-ийн өглөг	16,033.4	-
Банкны богино хугацаат зээл	300,000.0	-
Ногдол ашгийн өглөг	-	130,323.4
Урьдчилж орсон орлого	-	340,644.8
Бусад богино хугацаат өр төлбөр	204,635.5	104,737.2
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,034,989.2</b>	<b>823,442.0</b>
Урт хугацаат өр төлбөр	-	-
Урт хугацаат зээл	-	-
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,034,989.2</b>	<b>823,442.0</b>
<b>ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>	-	-
Өмч	10,380,728.7	-
б) хувийн	3,949,190.7	5,641,700.0
в) хувьцаат	6,431,538.0	-
Халаасны хувьцаа	-	-
Нэмж төлөгдсөн капитал	-	21,145,915.5
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	17,103,804.0	-
Хуримтлагдсан ашиг, алдагдал	422,913.0	767,914.7
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>27,907,445.7</b>	<b>27,555,530.2</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>28,942,434.9</b>	<b>28,378,972.2</b>

## ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

( '000 төгрөгөөр )

ҮЗҮҮЛЭЛТ	2018.06.30	2019.06.30
Борлуулалтын орлого (цэвэр)	639,350.0	1,118,083.5
Борлуулалтын өртөг	281,003.5	501,236.8
<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>358,346.5</b>	<b>616,846.8</b>
Түрээсийн орлого	-	-
Хүүний орлого	42,551.1	214,991.8
Бусад орлого	39,619.4	2,987.6
Борлуулалт, маркетингийн зардал	489,729.2	330,191.4
Ерөнхий ба удирдлагын зардал	114,123.6	280,477.1
Бусад зардал	-	78,425.0
Гадаад валютын ханшийн зөрүүний олз гарз	-2,136.4	-
Бусад ашиг (алдагдал)	-20,967.7	-
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>-186,439.9</b>	<b>145,732.7</b>
Орлогын татварын зардал	4,255.1	22,415.8
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>-190,695.0</b>	<b>123,317.0</b>
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>-190,695.0</b>	<b>123,317.0</b>

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

( '000 төгрөгөөр )

ҮЗҮҮЛЭЛТ	2018.06.30	2019.06.30
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	800,639.8	1,317,626.1
Бараа борлуулсан үйлчилгээ үзүүлсэний орлого	800,299.9	1,317,526.1
Бусад мөнгөн орлого	339.9	100.0
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>1,722,460.4</b>	<b>4,186,301.1</b>
Ажилчдад олгосон мөнгө	107,563.1	284,228.0
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	15,327.3	99,691.9
Түүхий эд материал худалдан авахад төлсөн мөнгө	802,458.1	3,039,409.8
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	26,447.0	52,160.4
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	36,754.5	140,805.7
Хүүний төлбөрт төлсөн мөнгө	7,041.1	144,074.0
Татварын байгууллагад төлсөн мөнгө	332,375.9	154,292.1
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	-	90.0
Бусад мөнгөн зарлага	394,493.4	271,549.1
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-921,820.6</b>	<b>-2,868,675.0</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>-</b>	<b>-</b>
Мөнгөн орлогын дүн	42,551.1	214,991.8
Хүлээн авсан хүүний орлого	42,551.1	214,991.8
Мөнгөн зарлагын дүн	407,218.4	55,322.5
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	331,033.4	45,034.5
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	10,288.0
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	76,185.0	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-364,667.3	159,669.4
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>6,635,063.4</b>	<b>3,007,905.4</b>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	300,000.0	2,665,000.0
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	6,335,063.4	-
Төрөл бүрийн хандив	-	1,450.1
Бусад орлого	-	341,455.3
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>510,000.0</b>	<b>3,044,343.2</b>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	510,000.0	2,965,000.0
Төлсөн ногдол ашиг	-	51,099.2
Бусад зарлага	-	28,244.0
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	6,125,063.4	-36,437.8
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	4,836,439.1	-2,745,543.5
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>115,260.0</b>	<b>3,909,193.1</b>
<b>Мөнгөн, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>4,951,699.1</b>	<b>1,163,649.6</b>

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

( '000 төгрөгөөр )

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2018 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл</b>	<b>3,949,190.7</b>	<b>17,103,804.0</b>	<b>613,608.0</b>	<b>21,666,602.8</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	3,949,190.7	17,103,804.0	613,608.0	21,666,602.8
Тайлангийн үеийн цэвэр ашиг	-	-	217,165.9	217,165.9
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	1,692,509.3	4,042,111.4	-	5,734,620.7
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
<b>2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>5,641,700.0</b>	<b>21,145,915.5</b>	<b>830,773.9</b>	<b>27,618,389.3</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	5,641,700.0	21,145,915.5	830,773.9	27,618,389.3
Тайлангийн үеийн цэвэр ашиг	-	-	123,317.0	123,317.0
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	(186,176.1)	(186,176.1)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
<b>2019 оны 06-р сарын 30-ний үлдэгдэл</b>	<b>5,641,700.0</b>	<b>21,145,915.5</b>	<b>767,914.7</b>	<b>27,555,530.2</b>

Маргаашийн хөгжлийг өнөөдөр хамтдаа бүтээнэ...

